



**МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ**

2015 оны 08 сарын 24 өдөр

Дугаар А/328

Улаанбаатар хот

Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны “Журам батлах тухай” 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, шинжлэх ухааны сайдын “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай” 2013 оны А/278 дугаар тушаалын хавсралт дахь Сэдванчиг овогтой Цэрэндашид холбогдох хэсгийн “Австри, Венийн их сургууль” гэснийг “Люксембургийн Вант Улс, Люксембургийн Санхүүгийн их сургууль” гэж, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай” 2015 оны А/22 дугаар тушаалын Гансүх овогтой Энхтөрд холбогдох хэсгийн “Австрали, Чарлз Стөрт их сургууль” гэснийг “Австрали, Ла Тробе их сургууль” гэж, Доржсүрэн овогтой Гантулгад холбогдох хэсгийн “Австрали, Сидней их сургууль” гэснийг “АНУ, Калифорни мужийн их сургууль” гэж, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай” 2015 оны А/155 дугаар тушаалын хавсралт дахь Батхишиг овогтой Ануд холбогдох хэсгийн “АНУ, Корнелл их сургууль” гэснийг “АНУ, Пенсилвани мужийн их сургууль” гэж, Хайрат овогтой Амиред холбогдох хэсгийн “Англи, Империа коллеж” гэснийг “АНУ, Аризона Мужийн их сургууль” гэж, Бямбажав овогтой Өгөөмөртэмүүлэнд холбогдох хэсгийн “Канад, Торонто их сургууль” гэснийг “Австрали, Сидней их сургууль” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Суралцагчтай зохих журмын дагуу гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дээд боловсролын хэлтэс /П.Эрхэмбулган/-т тус тус даалгасугай.



Л.ГАНТӨМӨР